



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/311

Сүхбаатар су...

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн улсын үзлэгийг эрчим хүчний
салбарт зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "е", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарийн хамтран баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг эрчим хүчний салбарт зохион байгуулах 2021 оны удирдамж"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Улсын үзлэгийг эрчим хүчний салбарт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөр болон улсын үзлэгийг хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

4.Зардлын тайланг 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ц.Туул/-д даалгасугай.

ДАРГА:  Ш. ОРГИЛ



430910771

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн
А/311 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга Ө.Сувдаа,

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Туул

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Б.Ганцолмон

Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагч Д.Машбат
Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын Улсын байцаагч Д.Хулан

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн
А/311 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

Энэхүү үзлэгийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцах, судалгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдэж байна.

Хоёр. Хамрах хүрээ:

Улсын үзлэгт Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал, Сайхан сумын эрчим хүчний салбар тус тус хамрагдана.

Гурав. Хугацаа:

Улсын үзлэгийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулах

Дөрөв. Үзлэгийн явцад танилцах асуудлын чиглэл:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, ажилтны талаарх хуулийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ажил олгогчийн эрх, үүргийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл/;
- Үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1/;
- Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйл/;
- Галын аюулгүй байдалд тавих шаардлага /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйл/;
- Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл/;
- Ажилтныг ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйл/;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын талаарх хуулийн заалтын хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх, үүргийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйл/;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйл/;
- Хөдөлмөрийн нөхцөлд хийсэн эрүүл ахуйн хэмжилт шинжилгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 35 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.4./ хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт/;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах 11.2.5./;
- Үйлдвэрлэл, зориулалттай машин, механизм тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн үзлэг хийх аргачлал:

5.1. Ажлын хэсгийн гишүүд үзлэгийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага дээр биечлэн очиж, танилцах аргаар хийнэ. Үзлэг зохион байгуулах удирдамжийн хавсралтаар баталсан хүснэгтийн дагуу тийм гэсэн хариултад 1 оноо, үгүй гэсэн хариултад 0 оноо тавьж үнэлнэ. Нийт хэдэн оноо авсанаар хувилж гаргана. Хүснэгтийн хаалтад "дүгнэхгүй" гэсэн асуултууд нь дүгнэлтэд орохгүй тоон дүнгээ тайланд бичигдэнэ.

Зургаа. Тайлан гаргах

Тайланг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлд ирүүлнэ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн
А/З/А тоот захирамжийн гуравдугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Хүний тоо	Хоног	Нэг бүр	Нийт
1	Томилолт	6	4	26500	636000
2	Шатахууны зардал	Мандал-Сүхбаатар	440	2070	145700
		Сайхан-Сүхбаатар	338	2070	111900
		Орхонтуул-Сүхбаатар	470	2070	155700
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ					
3	ХАБЭА-н гарын авлага хийх	300 ш		1500	450000
4	ХАБЭА-н сэтгүүл хэвлүүлэх	100 ш		9500	950000
5	ХАБЭА-н сэтгүүлийн эх бэлтгэл	1		80000	80000
	Нийт				2529300

Төсөв боловсруулсан:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ХАБЭА-н асуудал
хариуцсан мэргэжилтэн Ц.Туул

Хянасан:

АЗДТГ-ын СТСХ-н зарлагын

Ж.Хишигдэлгэр